ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/134/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.21 № 298

танай ____________-ны № ____________-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ЗИНА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Дээд шатны байгууллагын баталсан орон тооны жишиг нормд тусгагдаагүй архив бичиг хэргийн албан тушаалд хавсран гүйцэтгэсэнд цалин олгосон.
2. Нягтлан бодогчтой зэрэгцэн хөдөлмөрийн гэрээ байгуулан үндсэн цалин, бусад холбогдох нэмэгдлүүдийг олгосон.
3. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг худалдан авсан.

2125020265

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын цэцэрлэг нь 2025 онд 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 87.8 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **84,593,750.64** | **43,908,568.71** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 64,399,572.83 | 15,342,890.90 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 64,399,572.83 | 15,342,890.90 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 64,399,572.83 | 15,342,890.90 |
| **33** | **АВЛАГА** | **1,624,973.81** | **1,624,973.81** |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 1,624,973.81 | 1,624,973.81 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,569,204.00 | 26,940,704.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,569,204.00 | 26,940,704.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,902,704.00 | 16,809,104.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,666,500.00 | 10,131,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,070,945,195.90** | **1,842,740,413.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,070,945,195.90 | 1,842,740,413.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,070,945,195.90 | 1,842,740,413.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,215,440,000.00 | 2,215,440,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (272,037,165.12) | (466,769,766.96) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 12,740,000.00 | 12,740,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (5,095,999.92) | (7,643,999.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 63,972,633.90 | 63,972,633.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,084,843.78) | (33,879,370.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,373,452.76 | 73,753,452.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,687,877.78) | (30,292,543.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 29,550,000.00 | 29,550,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (11,824,994.16) | (17,729,992.20) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,600,000.00 | 3,600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,600,000.00 | 3,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,153,538,946.54** | **1,886,648,982.57** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **599,058.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 599,058.00 |
| **413** | **Өглөг** | - | 599,058.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 599,058.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 599,058.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,153,538,946.54** | **1,886,049,924.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,153,538,946.54 | 1,886,049,924.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 34,082,720.60 | 34,082,720.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 34,082,720.60 | 34,082,720.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,119,456,225.94 | 1,851,967,203.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,295,422,978.27 | 2,119,456,225.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (175,966,752.33) | (267,489,021.97) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,153,538,946.54** | **1,886,648,982.57** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **900,431,620.00** | **1,015,874,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,184,420.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,184,420.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 31,184,420.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **869,247,200.00** | **1,015,874,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 834,355,000.00 | 984,681,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 834,355,000.00 | 984,681,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 34,892,200.00 | 31,192,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,892,200.00 | 31,192,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,073,912,411.97** | **1,282,683,821.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,073,912,411.97** | **1,282,683,821.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,073,900,495.79 | 1,275,037,121.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 657,612,260.60 | 833,651,971.80 |
| 210101 | Үндсэн цалин | 399,554,476.15 | 469,360,997.03 |
| 210102 | Нэмэгдэл | 222,621,091.22 | 308,039,167.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 26,810,512.62 |
| 210104 | Урамшуулал | 35,436,693.23 | 29,441,294.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,910,431.94 | 97,443,936.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,787,202.39 | 66,099,984.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,506,199.18 | 7,796,749.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,401,331.70 | 4,067,417.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,203,199.14 | 3,899,598.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,012,499.53 | 15,580,187.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,330,083.82 | 22,778,491.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,399,001.44 | 17,765,367.40 |
| 210302 | Түлш, халаалт | 16,454,422.38 | 2,495,124.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,476,660.00 | 2,518,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,111,409.20 | 13,455,517.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 942,000.00 | 666,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,847,625.20 | 10,244,977.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,321,784.00 | 2,544,540.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 68,339,950.00 | 68,633,058.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 8,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,339,950.00 | 68,625,058.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,018,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,018,200.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 3,185,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,185,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 226,578,160.23 | 235,889,145.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,178,998.00 | 6,188,863.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 115,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 224,399,162.23 | 229,584,782.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11,916.18 | 7,646,700.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 7,646,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,646,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 11,916.18 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,916.18 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(173,480,791.97)** | **(266,809,021.97)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,485,960.36 | 680,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(175,966,752.33)** | **(267,489,021.97)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **869,247,200.00** | **1,015,874,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **869,247,200.00** | **1,015,874,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 834,355,000.00 | 984,681,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 834,355,000.00 | 984,681,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 34,892,200.00 | 31,192,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,892,200.00 | 31,192,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **862,480,739.78** | **1,064,931,481.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **862,480,739.78** | **1,064,931,481.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **862,468,823.60** | **1,057,284,781.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 660,389,515.59 | 833,651,971.80 |
| 210101 | Үндсэн цалин | 402,247,517.14 | 469,360,997.03 |
| 210102 | Нэмэгдэл | 222,621,091.22 | 308,039,167.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 26,810,512.62 |
| 210104 | Урамшуулал | 35,520,907.23 | 29,441,294.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,302,466.99 | 97,443,936.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,179,237.44 | 66,099,984.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,506,199.18 | 7,796,749.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,401,331.70 | 4,067,417.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,203,199.14 | 3,899,598.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,012,499.53 | 15,580,187.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,330,083.82 | 31,192,899.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,399,001.44 | 17,765,367.40 |
| 210302 | Түлш, халаалт | 16,454,422.38 | 9,716,732.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,476,660.00 | 3,710,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 68,339,950.00 | 68,026,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,339,950.00 | 68,026,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,550,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 4,550,200.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 3,185,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,185,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,556,607.20 | 23,784,973.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,891,107.20 | 18,315,273.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,665,500.00 | 5,469,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,916.18** | **7,646,700.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 7,646,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,646,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 11,916.18 | 0.60 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,916.18 | 0.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,766,460.22** | **(49,056,681.93)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 6,766,460.22 | (49,056,681.93) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 94,254,168.05 | 224,324,631.83 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 224,324,631.83 | 217,471,510.78 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 34,082,720.60 | | 2,295,422,978.27 | 2,329,505,698.87 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | | **-** | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (175,966,752.33) | (175,966,752.33) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **34,082,720.60** | **-** | **2,119,456,225.94** | **2,153,538,946.54** |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **34,082,720.60** | **-** | **2,119,456,225.94** | **2,153,538,946.54** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| Тайлант үеийн үр дүн | **-** | **-** | (267,489,021.43) | (267,489,021.43) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **34,082,720.60** | **-** | **1,851,967,204.51** | **1,886,049,925.11** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **64,399,572.83** | **(64,399,572.83)** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,047,187,600.00** | **1,033,738,581.93** | **13,449,018.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,047,187,600.00** | **1,033,738,581.93** | **13,449,018.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,039,540,900.00** | **1,026,091,881.93** | **13,449,018.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **839,068,500.00** | **833,651,971.80** | **5,416,528.20** |
| 210101 | Үндсэн цалин | 521,978,900.00 | 469,360,997.03 | **52,617,902.97** |
| 210102 | Нэмэгдэл | 292,168,400.00 | 308,039,167.65 | **(15,870,767.65)** |
| 210103 | Унаа хоол хөнгөлөлт | | 26,810,512.62 | **(26,810,512.62)** |
| 210104 | Урамшуулал | 24,921,200.00 | 29,441,294.50 | **(4,520,094.50)** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **104,009,600.00** | **97,443,936.93** | **6,565,663.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,562,400.00 | 66,099,984.60 | **4,462,415.40** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,361,800.00 | 7,796,749.86 | **565,050.14** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,180,900.00 | 4,067,417.17 | **113,482.83** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,180,900.00 | 3,899,598.30 | **281,301.70** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,723,600.00 | 15,580,187.00 | **1,143,413.00** |
| **2105** | **Нормативт зардал** | **68,529,600.00** | **68,026,000.00** | **503,600.00** |
| 210502 | Хоол хүнс | 68,529,600.00 | 68,026,000.00 | **503,600.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,199,300.00** | **3,185,000.00** | **14,300.00** |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 3,199,300.00 | 3,185,000.00 | **14,300.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **24,733,900.00** | **23,784,973.20** | **948,926.80** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,260,400.00 | 18,315,273.20 | **945,126.80** |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,473,500.00 | 5,469,700.00 | **3,800.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,646,700.00** | **7,646,700.00** | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,646,700.00 | 7,646,700.00 | **-** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,646,700.00 | 7,646,700.00 | **-** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,047,187,600.00** | **984,681,900.00** | **62,505,700.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 987,643,800.00 | 984,681,900.00 | **2,961,900.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 987,643,800.00 | 984,681,900.00 | **2,961,900.00** |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **59,543,800.00** | **-** | **59,543,800.00** |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 59,543,800.00 | - | **59,543,800.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 64,399,572.83 | **(64,399,572.83)** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 15,342,890.90 | **(15,342,890.90)** |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,562,300.00 | 17,765,367.40 | **(4,203,067.40)** |
| 21302 | Түлш халаалт | 12,552,600.00 | 9,716,732.00 | **2,835,868.00** |
| 21303 | Цэвэр, бохир ус | 5,078,000.00 | 3,710,800.00 | **1,367,200.00** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **31,192,900.00** | **31,192,899.40** | **0.60** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | **31,192,900.00** | 31,192,899.40 | **0.60** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 106.1 сая төгрөгийн 4 зөрчил[1] илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,555.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

### 3.1 Албан шаардлага

1. Дээд шатны байгууллагын баталсан орон тооны жишиг нормд тусгагдаагүй архив бичиг хэргийн албан тушаалд хавсран гүйцэтгэн цалин олгосон нь БШУС, СС-ын 2024 оны А/85/34 тушаалын 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.

2. Нягтлан бодогч зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад холбогдох нэмэгдлүүдийг тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" , Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 57 дугаар зүйлийн 57.3-т "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4-т "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.
4. Шилэн дансны 171 мэдээнээс 160 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, 5.0 төгрөгнөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 84,311,600 төгрөгийн орлогын 11 гүйлгээг мэдээллээгүй Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дээд шатны байгууллагын баталсан орон тооны жишиг нормд | 1 | 3,107.8 | | | 1 | 3,107.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тусгагдаагүй архив бичиг хэргийн албан тушаалд хавсран гүйцэтгэн цалин олгосон мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 150.0 хувиар тооцон олгосон | | | | | | | | | | | | |
| Нягтлан бодогч зэрэгцэн хөдөлмөрийн гэрээгээр үндсэн цалинг 100%, бусад холбогдох нэмэгдлүүдийг тооцоолон олгосон | 1 | 15,287.5 | | | 1 | 15,287.5 | | | | | | |
| Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг авсан. | 1 | 3,400.3 | | | 1 | 3,400.3 | | | | | | |
| **Дүн** | **3** | **21,795.6** | | | **2** | **21,795.6** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 11 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1 | 84,311.6 | | | 1 | 84,311.6 | | |
| **Нийт дүн** | **1** | 84,311.6 | | | **1** | 84,311.6 | | |